

10. ЗӨГИЙН АЖ АХУЙН БИЗНЕС МЕНЕЖМЕНТ



10-1. Таны зөгийн аж ахуй эрхэлж буй зорилго юу вэ?	185
10-2. Менежментийн нөөц гэж юу вэ?	185
10-2-1. Танд ямар нөөц байгаа вэ?	186
10-2-2. Өөрт байгаа нөөцийг нэгтгэж харъя!	186
10-3. Зөгийн бүлийг байршуулах тохиромжтой орчин гэж юу вэ?	188
10-4. Зардлаа тодорхой мэдэх үү?	189
10-5. Ирэх улирлын борлуулалтын төлөвлөгөө байгаа юу?	191

10-1. Таны зөгийн аж ахуй эрхэлж буй зорилго юу вэ?

Зөгийн бал бэлтгэн борлуулж ашиг олох зорилготой юу?

Хэрэв тийм бол энэ удаад зөгийн аж ахуйг хэрхэн үр ашигтайгаар эрхлэх тухай сэдэвт анхаарлаа хандуулна уу.

Та бүхэн зөгийн аж ахуй эрхлэхийн тулд эхлээд анхны хөрөнгө оруулалт хийх буюу тодорхой хэмжээний хөрөнгө санхүү зарцуулж зөгийн бүл, багаж хэрэгсэл зэрэг зүйлсийг худалдан авсан гэж бодож байна. Ингээд тодорхой хугацааны туршид үйл ажиллагаа явуулж, энэ хугацаанд урсгал зардал гарч байдаг. Үүний дараа зөгийн бал борлуулж олсон орлогоосоо мэдээж хоол хүнс, хувцас, шатахуун зэргийг худалдан авч ахуйн хэрэгцээндээ зарцуулах шаардлага үүсдэг. Гэвч анхны хөрөнгө оруулалт болон урсгал зардлаа нөхөх зайлшгүй шаардлагатай юм. Зөвхөн тухайн жил төдийгүй жил бүр л орлоготой, ашигтай байх нь таны зорилго билээ.

Иймээс ямар нэгэн үйл ажиллагаа эрхлэх, түүнийг байнгын тогтвортой орлоготой, ашигтай байлгахад чиглэсэн цогц үйл ажиллагааг “бизнес менежмент” гэж нэрлэдэг. Таны хэрэгжүүлж буй цогц үйл ажиллагааны үр дүнд бизнесийн тогтмол орлого, ашиг бий болохын төлөө хичээцгээе.

Үүний тулд танай үйл ажиллагаа танд болон таны үйлчлүүлэгчдэд ч бас “өгөөжтэй” байх ёстой. Таны нийлүүлэх бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээ нь үйлчлүүлэгчдэд ямар нэгэн “үнэ цэнэ” авчирснаар үйлчлүүлэгч бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдаж аван борлуулалт хийгдэж, тухайн борлуулалтын орлого нь зардлаасаа давж гарвал танд ашиг болж ирдэг.

Тухайн орлогоо нэмэгдүүлэхийн тулд ирээдүйд үнэ цэнийг тогтвортой байлгах (тогтвортой байдал), харьцангуй бага зардлаар их хэмжээний борлуулалт (бүтээмж) хийх нь маш чухал юм.

10-2. Менежментийн нөөц гэж юу вэ?

Менежментийн нөөцөд хүн, эд зүйлс, хөрөнгө мөнгө, мэдээлэл багтана.

Хүн хүч: Та өөрөө болон танай гэр бүлийнхэн, ажилчид зэрэг хүний нөөц, чадавх

Эд зүйлс: Газар, байгууламж, үйлдвэрлэлийн хөрөнгө, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, түүхий эд гэх мэт

Хөрөнгө мөнгө: Өөрийн хөрөнгө, хөрөнгө босгох чадвар, борлуулалт, зардал

Мэдээлэл: Технологи, ноу-хау, хэрэглэгчийн болоод бусад компанийн талаарх мэдээлэл, брэндийн хүч, патент, ур чадвар гэх мэт

10-2-1. Танд ямар нөөц байгаа вэ?

Юу ч байхгүй мэт санагдаж байвч гэр бүлийн гишүүд, үйл ажиллагаа эрхлэхэд ашиглаж болох багаж хэрэгслүүд нь танд буй нөөц боломжийн нэг хэсэг юм. Өнөөг хүртэл эзэмшсэн ажлын туршлага, бусдаас мөнгө зээлэх боломж зэрэг нь бас нөөцийн нэг хэлбэр байдаг.

Өөрт байгаа нөөцөө ашиглаж зардлаа аль болох багасгаж стандартыг чандлан мөрдсөн бүтээгдэхүүн үйлдвэрлэснээр хэрэглэгчид ижил төрлийн бүтээгдэхүүн дундаас зөвхөн таны “бүтээгдэхүүн”-ийг л сонгож авдаг байх нь чухал юм.

Та бол зөгийчин хүн учраас зөгийн аж ахуйг өөрийн бизнес болгон эрхэлж, зөгийн аж ахуйгаас орлого олж байгаа.

Зөгийн аж ахуйд зөгийн бүл, үүр хайрцаг, шаардлагатай багаж хэрэгслээс гадна өвөлжилтөнд бэлтгэх, зөгийн өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа гэх мэтчилэн зөгийн маллагааны технологи мөн хүнсний стандарт болон эрүүл ахуйн шаардлага хангаж ажиллахтай холбоотой мэдлэг шаардлагатай болно. Зөгийн аж ахуйд байгаль орчин болоод нийгмийн хүчин зүйл хэрхэн нөлөөлөх зэргийг мэдэж байх зайлшгүй шаардлагатай

Өөрт байгаа нөөц боломжийг ашиглаж, хүрээлэн буй орчноо судалж, хэрэгцээт зүйлсээ бэлтгэснээр танд зөгийн аж ахуй эрхлэх боломж бүрдэнэ.

10-2-2. Өөрт байгаа нөөцийг нэгтгэж харъя!

Зөгийн аж ахуй эрхлэхэд олон төрлийн багаж хэрэгсэл, зарим тоног төхөөрөмж шаардагдана.

Ихэнх зөгийн аж ахуй зөгийн маллагаа, бал хураалт, бүтээгдэхүүн бэлтгэх, борлуулах хүртэлх бүхий л үйл явцыг цогцоор нь хэрэгжүүлдэг. Тэрхүү үйл явц бүрт шаардлагатай эд зүйлс гэж бий.

Танд одоо хир зэрэг нөөц байна вэ?

Гол шаардлагатай эд зүйлс, зардал:

ЗӨГИЙН АЖ АХУЙН НЭГДСЭН ГАРЫН АВЛАГА

Үйл явц	Шаардлагатай эд зүйлс, зардал	Үйл явц	Шаардлагатай эд зүйлс, Зардал
Зөгийн бүлд арчилгаа, маллагаа хийх	Зөгийн бүл	Зөгийн бал хураах	Бал ялгуур
	Нөөц үүр хайрцаг		Хадгалах сав
	Давхарлагааны корпус		Шүүлтүүр
	Жааз		Хутга
	Сэмж		Сахар хэмжигч
	Идүүр		Шинжилгээний төлбөр
	Хашлага самбар	Бүтээгдэхүүн бэлтгэх	Зөгийн балаа савлах сав
	Эх зөгий тусгаарлагч тор		Шошго
	Дэр		Амталгаа хийхэд ашиглах зүйлс
	Цаваг даавуу		Эрүүл ахуйн хувцас
	Услуур	Борлуулалт хийх	Борлуулалт сайжруулах зүйлс
	Сахар (тэжээл)		Сурталчилгааны хуудас
	Уурагт тэжээл		Үзэсгэлэнд оролцох мэдээлэл, зардал
	Хачгийн эм		Тээврийн зардал
	Бусад эм бэлдмэл		Ажиллах хүч
	Өвөлжөө, өвөлжилтөд хэрэгтэй эд зүйлс	Бусад үйл ажиллагаа	Ажилчдын хоол хүнс
	Ховхчуур, зөгийн шүүр		Харилцаа холбооны зардал
	Бээлий		Дулаан, цахилгааны зардал
	Торон малгай		Гар утас
	Зөгийчний хувцас		Нүүдэл хийх (машин г.м)
	Бүртгэлийн дэвтэр		Шатахуун
	Мал эмнэлгийн үйлчилгээний төлбөр		Түрээсийн төлбөр (газар г.м)

Зөгийн маллагааны дараагийн улиралд шаардлагатай эд зүйлсийн тоо хэмжээ болон одоо бэлэн байгаа тоо хэмжээ хоорондын зөрүү нь дутагдаж байгаа хэсэг юм. Дутуу зүйлсийг гүйцээж бэлтгэх шаардлагатай.

Төлөвлөгдсөн үйл ажиллагаа, худалдан авалт хийхэд шаардагдах зардлыг тооцоолж шаардлагатай бол дараагийн улирлын зөгийн маллагааны төлөвлөгөөг эргэж засварлах ёстой.

Мөн бусад гадны хүчин зүйлүүдийг тооцох шаардлагатай.

10-3. Зөгийн бүлийг байршуулах тохиромжтой орчин гэж юу вэ?

- Зөгий маллахад ямар орчин тохиромжтой вэ?

Улирал тутамд балт болон тоост ургамлын хангалттай нөөцтэй байх
Услуур бэлтгэсэн байх (хэрвээ байхгүй бол бэлтгэх)
Бэлчээр нь гурван км-ын тойрогт хүнд метал зэргээр бохирлогдоогүй байх
Хог хаягдал болон муу усны цооног зэргийг хамгаалсан байх
Газар тариалан, хадлан, бэлчээрийн талбайг ашиглах боломж бүрдсэн байх

- Зөгийн бал савлах тохиромжтой орчин гэж юу вэ?

Тоос шороо, хог, хорхой шавьж зэрэг гадны бохирдол орохооргүй эрүүл ахуйн шаардлага хангасан газар байх
Гар угаах болон цэвэрлэгээ хийх боломжтой байх
Шил болон багажийг ариутгах боломжтой байх
Малгай, маск, хормогч зэрэг бэлдсэн байх

- Ашиглах боломжтой нийгмийн орчин юунаас бүрдэх вэ?

Бүтээгдэхүүнийг тээвэрлэх нөхцөл бүрдсэн байх
Худалдан авагч байгаа эсэх
Мал эмнэлэгтэй хамтран ажиллах боломжтой эсэх
Хяналт, шинжилгээний харъяалагдах байгууллага нь тодорхой байх
Зөгийн маллагаатай холбоотой мэдээллийн эх сурвалж байгаа эсэх
Банк, санхүүгийн байгууллагаас зээл авах боломжтой эсэх

10-4. Зардлаа тодорхой мэдэх үү?

Зөгийн аж ахуй эрхлэх явцад байнгын зардал нэлээдгүй гарна. Эд зүйлс худалдаж авахын зэрэгцээ цалин хөлс, шатахуун зэрэг хөрөнгө болж үлдэхгүй урсгал зардал гардаг. Эдгээр зардал нь улирлаас хамааран мөнгөн дүнгийн хувьд харилцан адилгүй байдаг билээ.

Зөгийн аж ахуйн менежментийг хөтлөхийн тулд зардал болон борлуулалтын орлогын тэнцвэрийг сайтар тооцох хэрэгтэй. Хэрэв таны борлуулалтын орлогоос зарцуулсан мөнгөн дүн удаан хугацаанд их байгаа бол бизнесийн зорилгоор зөгийн аж ахуй эрхлэх нь утгагүй юм.

Зөгийн аж ахуйгаас орж буй орлого нь зөгийн бал, цэцгийн тоос, жилий, лав гэх мэт тодорхой хэдэн эх үүсвэрээс бүрдэх боловч зардлын их багын хэмжээ нь цаг хугацааны хувьд өөр өөр байдаг тул тухай бүр бүртгэл хөтлөх хэрэгтэй. Тухайлбал зөгийн маллагаанд хэдэн төгрөг зарцуулснаа тодорхой мэдэхгүй байдалд хүрдэг. Харьцангуй бага хэмжээний 100 төг, эсвэл 500 төг байсан ч тэр нь 10 дахин, 20 дахин давтагдах тохиолдолд нийлбэрээрээ мөнгөн дүн нь их гарах болно.

Мөн зардлууд аль цаг үед гарч байгаа нь бас чухал юм. Жилийн нийт зардлыг урьдчилан бэлтгэх шаардлагагүй, тухай тухайн үед худалдан авалт хийх мөнгийг л бэлдсэн байх шаардлагатай.

Иймээс зайлшгүй шаардлагатай зардлыг орхигдуулахгүйн тулд агуулга тус бүрээр төлөвлөж тооцооны хүснэгтэнд тэмдэглэцгээе.

Гэвч шаардлагагүй буюу үр ашиггүй зардал гаргахаас болгоомжлох нь чухал юм.

Тухайлбал шаардлагатай эсэхийг сайн судлаагүй зүйлсийг яаран худалдан авахгүй байх хэрэгтэй.

ЗӨГИЙН АЖ АХУЙН НЭГДСЭН ГАРЫН АВЛАГА

Зардлаа бүртгэгцгээе!

<Жишээ>

Сар 4-р	Зорилт				
	Ажлын төлөвлөгөө				
	Шаардлагатай зүйлсийг худалдаж авах төлөвлөгөө				
Зөгийн маллагаанд шаардлагатай зүйлс		Тэжээл, жааз, сэмж, төмөр утас, үүр хайрцаг, ховхчуур, дэр, зөгийн бүл зэрэг			
Сар, өдөр	Худалдаж авсан зүйлүүд	Хаана төлсөн	Мөнгөн дүн	Тайлбар	
Нийт					
Савлагаа, бүтээгдэхүүн бэлтгэхэд шаардлагатай зүйлс		Балны шил, шонго, шүүлтүүр, ажлын хувцас, сахар хэмжигч			
Сар, өдөр	Худалдаж авсан зүйлүүд	Хаана төлсөн	Мөнгөн дүн	Тайлбар	
Нийт					
Улирал тутмын шаардлагатай зүйлс		Малын эмчийн үйлчилгээ, эм авах, зөгийн суурийн нүүдэл, өвөлжөөны засвар зэрэг			
Сар, өдөр	Төлбөрийн утга	Хаана төлсөн	Мөнгөн дүн	Тайлбар	
Нийт					
Борлуулалтад шаардлагатай зүйлс		Бүтээгдэхүүн тээвэрлэлт, зар суртчилгаа, борлуулалтын үеийн бусад зардал зэрэг			
Сар, өдөр	Төлбөрийн утга	Хаана төлсөн	Мөнгөн дүн	Тайлбар	
Нийт					
Хөдөлмөр хөлсний зардал		Гэр бүлээрээ, туслах ажилчин			
Хэн	Хоног	Нийт хоногийн тоо	Нийт	Нийгмийн даатгал	Нийт
Нийт					
Бусад					
Сар өдөр	Төлбөрийн утга	Төлөлт	Мөнгөн дүн	Тайлбар	
Нийт					
Тэмдэглэл:				4-р сарын нийт дүн	

10-5. Ирэх улирлын борлуулалтын төлөвлөгөө байгаа юу?

Та ирэх улиралд зөгийн аж ахуйгаас хэдэн төгрөгийн орлого олох вэ?

Зардлаа хасаад ашиг нь хэд байх вэ? Үүний тулд ямар хэмжээний борлуулалт хийхийг зорьж байна вэ?

Тодруулбал ашгийн хэмжээ (цэвэр ашиг) хэд байхын тулд борлуулалтын хэмжээ хэд байх шаардлагатайг төсөөлж үзье.

Зорилтот тоо, хэмжээгээ тогтоогоод түүнийг биелүүлэхэд ямар үйл ажиллагаа хэрэгжүүлэх шаардлагатай вэ? Тухайлбал борлуулах бүтээгдэхүүний төрөл, үнэ өртөг, хэмжээ, мөн зөгийн маллагааны аргад өөрчлөлт хийх тухай бодоцгооё!

Төлөвлөгөө

Ашиг (цэвэр ашиг): _____ төг

Жилийн нийт зардал: _____ төг

Борлуулалтын орлого: _____ төг

Борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх бүтээгдэхүүний борлуулалт:

А төрлийн бүтээгдэхүүн : нэгж үнэ _____ төг × _____ ширхэг

В төрлийн бүтээгдэхүүн : нэгж үнэ _____ төг × _____ ширхэг

С төрлийн бүтээгдэхүүн : нэгж үнэ _____ төг × _____ ширхэг

Д төрлийн бүтээгдэхүүн : нэгж үнэ _____ төг × _____ ширхэг

Жишээлбэл: Нэг төрлийн байгалийн балт ургамлын бал (А төрөл), байгалийн олон цэцгийн бал (В төрөл), таримал ургамлын холимог бал (С төрөл), нэг төрлийн таримал ургамлын бал (D төрөл) гэж хувааж болно.

Борлуулалтаа дээшлүүлэхийн тулд 1) ямар төрлийн бүтээгдэхүүн (зөгийн бал)-ийг 2) хэдэн төгрөгөөр 3) ямар хэмжээгээр борлуулахыг хүсч байна вэ, үүний тулд 4) хэзээ, аль бэлчээрийг ашиглах 5) зөгийн бүл тутмаас хэдэн кг зөгийн бал хураахыг зорих вэ, 6) хэдэн бүл зөгий шаардлагатай зэргийг нийтэд нь төлөвлөж тооцох боломжтой.

Ирэх улирлын зөгийн маллагааны төлөвлөгөө.

Борлуулалт болон төлбөрийн төлөвлөгөөг нэг хуудаст нэгтгэж харцгаая.

Сар бүрийн орлого зарлагын төлөвлөгөөг нэгтгэж харснаар хэзээ хүртэл ямар хэмжээгээр, юуг бэлтгэх шаардлагатайг төлөвлөж болно.

Үйлдвэр,гэлийн төлөвлөгөө он												Бэлгэсэн сар, өдөр		
Борлуулалтын төлөвлөгөө			Төг			Ашгийн зорилт			Төг			Зорьж буй ашгийн хувь		%
Бизнесийн төлөв												(кг/ төг)		
Борлуулалт	Зөгийн бал	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	1 сар	2 сар	Жилийн нийт дүн
	Бусад													
	Нийт дүн													
	Энгийн зардал													
	Онцгой зардал													
Зардал	Нийт дүн													
Хүлээгдэж буй орлого														

※Бусад: Зөгийн бүл, жилий, эх зөгий борлуулах, зөгий маллагааны хөлс, тоос хүртээлтэнд зөгийн бүл түрээслүүлэх өвөлжөө түрээслэх г.м

※※※ Тусгай зардал: Жил бүр зардал гаргахгүй боловч цар хүрээгээ тэлэх гэх мэтээр зөвхөн тухайн үед л гарах тусгай зардал

Борлуулалтаа нэмэгдүүлэх стратеги (зорилт)							
Онцлог • Тайлбар	Борлуулалтын нийт үнэ	Нэгж үнэ	Бал хураалтын хэмжээ	Нэг бүл тутмын бал хураалтын хэмжээ	Шалдлагатай бүлийн тоо	Одоо байгаа бүлийн тоо	Хулацдаг авах бүлийн тоо
Зөгийн балны төрөл ①		төг = төг ×	кг	кг	бүл	бүл	бүл
Зөгийн балны төрөл ②		төг = төг ×	кг	кг	бүл	бүл	бүл
Зөгийн балны төрөл ③		төг = төг ×	кг	кг	бүл	бүл	бүл
Нийт	төг				бүл	бүл	бүл